



СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

Статистикийн танилцуулга

2017/12



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2017 ОН	2
 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	3
 ДҮҮРГИЙН ТӨСӨВ	6
 АЖ ҮЙЛДВЭР	8
 ХӨДӨӨ АЖ АХУЙ	10
 БАРИЛГА	14
 ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ	15
 МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО	15
 НИЙТИЙН ТЭЭВЭР	15
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	16
 НИЙГМИЙН ДААТГАЛ	16
 ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ	19
 ЭРҮҮЛ МЭНД	20
 БОЛОВСРОЛ	21
 ГЭМТ ХЭРЭГ	22
 АМЬДАРЧ БУЙ ОРЧИН	24
ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ	25

Хүснэгт 1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн XII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017*
Шинээр төрсөн хүүхэд	тоо	4510	4613	4400
Бүртгэлтэй ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	1350	1891	565
үүнээс: эмэгтэй	хүн	643	942	328
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн	тоо	3123	3347	2386
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	1390	1639	1900
Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлт	хувь	1.1	0.5	7.2
Валютын зах зээлийн ханш, сарын эцэст	1US\$ =₮	1 995.5	2489.5	2 427.1
Дүүргийн төсвийн орлого	тэрбум төгрөг	47.3	52.6	58.5
Дүүргийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	42.6	47.6	51.6


*-2017 оны урьдчилсан гүйцэтгэл



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны хэрэглээний үнийн индекс 2016 оны эцэстэй харьцуулахад 7.2 хувиар, өмнөх 11-р сартай харьцуулахад 0.3 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2017 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 7.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 3.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 5.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 10.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 5.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 10.7 хувь, тээврийн үйлчилгээ 10.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ 4.1 хувь, боловсролын үйлчилгээ 7.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 2.6 хувь, бусад бараа, үйлчилгээний үнэ, тариф 8.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2015-XII</u> 2014-XII	<u>2016-XII</u> 2015-XII	<u>2017-XII</u> 2016-XII	<u>2017-XII</u> 2017-XI
Ерөнхий индекс	101.1	100.5	107.2	100.3
Хүнсний бараа, ундаа, ус	92.8	101.4	107.9	99.7
Согтууруулах ундаа, тамхи	100.6	104.0	103.9	100.4
Хувцас, бөс бараа, гутал	102.1	98.6	105.1	100.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	103.1	97.2	110.2	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	105.4	100.8	105.2	100.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	104.4	107.8	110.7	102.6
Тээвэр	100.7	99.0	110.5	100.7
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.3	100.7	99.6	99.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.9	99.2	104.1	100.6
Боловсролын үйлчилгээ	123.6	102.6	107.5	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	103.5	101.2	102.6	102.5
Бусад бараа, үйлчилгээ	105.8	102.2	108.7	100.5

2017 оны 12-р сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 22.1 хувийнх нь үнэ өсч, 11.9 хувийнх нь үнэ буурч, 66.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байлаа.

Хүснэгт 3. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.3	Энэ бүлгийн бууралтад талх, гурил, будаа 0.1 хувиар, мах, махан бүтээгдэхүүн 2.9 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.
Согтууруулах ундаа, тамхи	0.4	Энэ бүлгийн өсөлтөд архи, спирт 0.6 хувиар, дарс 0.5 хувиар, тамхи 0.3 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Хувцас, бөс бараа, гутал	0.1	Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн өсөлтөд хөвөн, бөс бараа 5.6 хувиар, бүх төрлийн хувцас 0.1 хувиар, жижиг эдлэл, хэрэгсэл 0.1 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.3	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн өсөлтөд гэр ахуйн оёмол, нэхмэл эдлэл 1.9 хувиар, гэр ахуйн удаан эдэлгээт цахилгаан болон бусад бараа 0.4 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	2.6	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь эм, тариа 4.0 хувиар, шүдний эмнэлгийн үйлчилгээ 3.7 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр	0.7	Тээврийн үйлчилгээний бүлгийн өсөлт нь автомашин, мотоцикл 2.0 хувиар, тээврийн хэрэгслийн үйлчилгээ 15.0 хувиар тус тус өссөнөөс шалтгаалсан байна.
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	-0.4	Энэ бүлгийн бууралтад телефон аппарат, факсын хэрэгсэл 9.6 хувиар буурсан нь нөлөөлжээ.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.6	Энэ бүлгийн өсөлтөд фото зураг, кино зургийн хэрэгсэл, дуран 36.8 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	2.5	Энэ бүлгийн өсөлтөд гуанз, цайны газрын үйлчилгээ 4.9 хувиар өссөн нь шууд нөлөөлжээ.
Бусад бараа, үйлчилгээ	0.5	Бусад бараа, үйлчилгээний өсөлт нь үсчин болон гоо сайхны үйлчилгээ 2.1 хувиар, хувь хүний бусад эд зүйлс 1.5 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны XII сарын танилцуулга


2017 оны 12-р сарын 27-ны өдрийн үнийн ажиглалтаар Хан-Уул дүүргийн хүнсний зах, дэлгүүрүүдээр худалдаалагдаж байгаа хүнсний өргөн хэрэглээний 16 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хонины мах 400 төгрөг, элсэн чихэр 100 төгрөг, байцаа 300 төгрөг, сонгино 700 төгрөг, фүжи алим 500 төгрөгөөр тус тус буурч, үхрийн мах 10000 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн дээд зэргийн гурил 140 төгрөг, “Алтан тариа” ХК-ийн 1-р зэргийн гурил 50 төгрөг, төмс 100 төгрөг, лууван 100 төгрөг, манжин 950 төгрөг, цагаан будаа 500 төгрөг, задгай сүү 400 төгрөг, “Сүү” ХК-ны цөцгийтэй тараг 490 төгрөгөөр тус тус өссөн байна. Харин “Талх чихэр” ХК-ны Атар талх, “Алтан тариа” ХК-ийн 2-р зэргийн гурилны үнэ тогтвортой байлаа.

Хүснэгт 4. Хүнсний өргөн хэрэглээний барааны дундаж үнэ*, төгрөг, жил бүрийн XII сард


Бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	2016	2017	$\frac{2017}{2016} \%$
Талх “Атар”, “Талх чихэр” ХК	ширхэг	1 160	1 160	100.0
Хонины мах, ястай	кг	4 300	3 900	90.7
Үхрийн мах, ястай	кг	5 500	6 500	118.2
Гурил , дээд зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	1 310	1 450	110.7
Гурил ,1-р зэрэг, “Алтан тариа” ХК, задгай	кг	1 070	1 120	104.7
Гурил, 2-р зэрэг, “Алтан тариа” ХК, савласан	кг	900	900	100.0
Элсэн чихэр	кг	2 300	2 200	95.7
Төмс, монгол	кг	800	900	112.5
Байцаа, монгол	кг	1 800	1 500	83.3
Лууван, монгол	кг	1200	1 300	108.3
Манжин, монгол	кг	1 200	2 150	179.2
Сонгино, хятад	кг	2000	1 300	65.0
Цагаан будаа	кг	2 300	2 800	121.7
Алим, фүжи	кг	4 000	3 500	87.5
Сүү, задгай	литр	1 400	1 800	128.6
Тараг, цөцгийтэй, “Сүү” ХК	литр	2 150	2 640	122.8

*- Худалдаа үйлчилгээний “Мөнхсүврага” төв


Зураг 2. Нэг кг махны дундаж үнэ, төгрөг



Зураг 3. Нэг кг гурилын дундаж үнэ, төгрөг



Зураг 4. Нэг кг төмс, лууван, байцааны дундаж үнэ, төгрөг



Зураг 5. Нэг кг манжин, сонгины дундаж үнэ, төгрөг



Хүснэгт 5. Нэг литр шатахууны үнэ, төгрөг


ШТС	2016.XII.28					2017.XII.27				
	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ	Аи 95	Аи 80	Аи 92	Дизель түлш	Газ
Жаст Ойл	1 730	1 450	1 530	1 640		1 820		1 630	1 720	
Петровис	1 730	1 450	1 530	1 640		1 820	1 480	1 630	1 720	
Магнай трейд	1 730	1 450	1 530	1 640		1 820	1 480	1 630	1 720	
Сод монгол	1 730		1 550	1 640		1 820		1 630	1 720	
Шунхлай		1 450	1 530	1 640				1 630	1 720	
Юнигаз					900					1 050
Дундаж үнэ	1 730	1 450	1 530	1 640	900	1 820	1 480	1 630	1 720	1 050



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 58.6 тэрбум төгрөг болж, төсвийн орлого төлөвлөснөөс 1.4 тэрбум төгрөгөөр (2.4%) илүү бүрдсэн бөгөөд орлогын бүрдэлт 2016 оноос 11.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Төсвийн нийт орлогын 31.8 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 6.6 хувийг татварын бус орлого (нийтлэг татварын бус орлого), 61.6 хувийг улсын төсөв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна.

Зураг 6. Төсвийн орлого, зарлага, 2013-2017 он, сая төгрөг



Татварын орлогын хэмжээ 18.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 218.4 сая төгрөгөөр (1.2%), татварын бус орлого 3.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.2 тэрбум төгрөгөөр (45.6%) түс түс илүү бүрдсэн байна.

Хүснэгт 6. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, сая.төг

	Төсвийн орлого			Үүнээс:					
				Татварын орлого			Татварын бус орлого		
	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү	Бүгд	Биелэлт хувиар	Зөрүү
Дүүргийн дүн	58 553.6	102.4	1 391.2	18 654.0	101.2	218.4	3 840.1	145.6	1 201.9

Орлогын албан татвар төлөвлөснөөс 3.0 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар төлөвлөснөөс 18.2 сая төгрөгөөр тус тус илүү бүрдсэн бол, бусад татвар, төлбөр, хураамж төлөвлөснөөс 2.8 тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна.

Хүснэгт 7. Дүүргийн төсвийн орлого, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү
Нийт орлого	57 162.4	58 553.6	102.4	1 391.2
1.Татварын орлогын дүн	18 435.6	18 654.0	101.2	218.4
Орлогын албан татвар	8 816.2	11 854.6	134.5	3 038.4
Хувь хүний орлогын албан татвар	8 816.2	11 854.6	134.5	3 038.4
Хөрөнгийн албан татвар	37.0	55.2	149.1	18.2
Бусад татвар,төлбөр, хураамж	9 582.4	6 744.2	70.4	-2 832.2
Улсын тэмдэгтийн хураамж	7 847.2	5 285.6	67.4	-2 561.6
Ашигт малтмал ашигласны төлбөр	78.0	74.8	95.9	-3.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1 657.2	1 383.9	83.5	-273.3
2.Татварын бус орлогын дүн	2 638.2	3 840.1	145.6	1 201.9
Торгуулийн орлого	1 501.9	2 752.9	183.3	1 251.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1 056.3	768.9	72.8	-287.4
Бусад орлого	80.0	318.2	397.8	238.2
3. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	36 088.6	36 059.5	99.9	-29.1
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35 799.1	35 770.0	99.9	-29.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	289.6	289.6	100.0	-

2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс төсөвт байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 51.6 тэрбум төгрөгийг (98.3%) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл төсөвт байгууллагууд үйл ажиллагааны нийт зардлын 904.7 сая төгрөгийг (1.7%) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Зураг 7. Татварын орлогын бүтэц, хувиар



Зураг 8. Татварын бус орлогын бүтэц, хувиар



Төсвийн нийт зарлагын 42.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 4.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 7.8 хувийг татаас болон урсгал шилжүүлэг, 45.2 хувийг бараа, ажил үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Хүснэгт 8. Дүүргийн төсвийн орлого, зарлага, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр, сая төгрөг

	Орлого	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Дүүргийн дүн	58 553.6	52 529.4	51 624.7	98.3	-904.7	6 928.9


Дүүргийн төсвөөс болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагууд тухайн сарын эхэнд 176.4 сая төгрөгийн өглөгтэй байсан бөгөөд 176.4 сая төгрөгийн өглөгийг төлж барагдуулан оны эцэст өглөггүй болсон байна.



АЖ ҮЙЛДВЭР


Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 934.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 892.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 16.7 хувиар, борлуулалт 26.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 9. Аж үйлдвэрийн үйлдвэрлэлт, борлуулалт, 2016-2017 оны сар бүрээр, тэрбум төгрөг




Аж үйлдвэрийн нийт борлуулалтын 722.6 тэрбум төгрөгийг дотоодод, 169.7 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна. Нийт борлуулсан бүтээгдэхүүний 19.0 хувийг экспортод гаргасан бөгөөд нийт экспортын 90.7 хувийг ноос, ноолуур, нэхмэлийн үйлдвэрлэлт, 7.4 хувийг арьс ширний үйлдвэрлэлт, 0.6 хувийг ундаа үйлдвэрлэлт, 0.6 хувийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, 0.7 хувийг бусад ашигт малтмал олборлолт тус тус эзэлж байна.

Зураг 10. Үйлдвэрлэлт, 2015-2017 он, тэрбум төг



Зураг 11. Борлуулалт, 2015-2017 он, тэрбум төг



Хүснэгт 9. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Нийт бүтээгдэхүүн		
	2016	2017	$\frac{2017}{2016} \%$
	I-XII сар	I-XII сар	
Уул уурхай олборлох үйлдвэр	18594.3	19652.8	105.7
Төмрийн хүдэр олборлолт	17793.1	18498.9	104.0
Бусад ашигт малтмал олборлолт	801.2	1153.9	144.0
Боловсруулах үйлдвэр	678565.9	804715.2	118.6
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	344931.5	334170.2	96.9
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	3618.9	4790.1	132.4
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2325.1	16291.2	7.0*
Хүнсний бусад бүтээгдэхүүн	25791.7	32958.6	127.8
Ундаа үйлдвэрлэл	313195.8	280130.3	89.4
Нэхмэлийн үйлдвэрлэлт	253698.2	326863.6	128.8
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2332.6	5628.0	2.4*
Арьс шир боловсруулах үйлдвэр	11221.4	18531.2	165.1
Мод, модон эдлэл	2972.8	8017.2	2.7*
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4990.4	9235.2	185.1
Хэвлэл болон дуу бичлэгийн үйл ажиллагаа	6112.3	6905.1	113.0
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	37687.6	74346.6	1.9*
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	9149.7	9249.1	101.1
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	3796.8	9305.6	2.4*
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	260.9	318.5	122.1
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	52.1	392.5	4.5*
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1002.1	1353.8	135.1
Мебель тавилга үйлдвэрлэл	357.5	398.6	111.5
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	104237.2	110563.2	106.1
ДҮН	801397.4	934931.2	116.7

*-дахин

Хүснэгт 10. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний борлуулалт, салбараар, өссөн дүнгээр /оны үнээр, сая төгрөг/

Салбараар	Аж үйлдвэрийн борлуулалт			
	2016	2017	$\frac{2017}{2016} \%$	үүнээс: экспорт, %
	I-XII cap	I-XII cap		
Уул уурхай олборлох үйлдвэр	18594.3	19652.8	105.7	0.1
Төмрийн хүдэр олборлолт	17793.1	18498.9	104.0	-
Бусад ашигт малтмал олборлолт	801.2	1153.9	144.0	100.0
Боловсруулах үйлдвэр	581591.8	762139.9	131.0	22.1
Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	289704.0	347754.4	120.0	0.6
Мах, загас, ногоо, тос боловсруулалт	5009.2	3895.2	77.8	26.2
Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2761.2	17782.7	6.4*	
Хүнсний бусад бүтээгдэхүүн	25233.5	32122.3	127.3	
Ундаа үйлдвэрлэл	256700.1	293954.2	114.5	0.3
Нэхмэлийн үйлдвэрлэлт	204688.4	261209.4	127.6	58.9
Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт	2132.9	5626.2	2.6*	
Арьс шир боловсруулах үйлдвэр	11349.6	18141.8	159.8	69.8
Мод, модон эдлэл	2972.8	8300.0	2.8*	
Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4987.0	9235.2	185.2	
Хэвлэл болон дүү бичлэгийн үйл ажиллагаа	8902.5	7011.0	78.8	
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	42084.9	83367.4	1.9*	
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүн	9149.7	9432.7	103.1	
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл	3880.0	9383.3	2.4*	
Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл	259.5	318.5	122.7	
Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл	95.4	392.5	4.1*	
Эмнэлгийн багаж хэрэгсэл үйлдвэрлэл	1027.6	1568.9	152.7	
Мебель тавилга үйлдвэрлэл	357.5	398.6	111.5	
Цахилгаан, хий, дулаан үйлдвэрлэлт	104237.2	110563.2	106.1	
ДҮН	704423.3	892355.9	126.7	19.0


*-дахин



ХӨДӨӨ АЖ АХУЙ

Дүүргийн 2017 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор нийт 38485 мал тоологдож өнгөрсөн оны мөн үеэс 375 (1.0%) толгой малаар буурсан байна. Тоологдсон нийт малын төрлөөр нь авч үзвэл, адуу 6247 толгой (16.2%), үхэр 12616 толгой (32.8%), хонь 9894 толгой (25.7%), ямаа 9727 толгой (25.3%), тэмээ 1 толгой тус тус тоологджээ.

Зураг 12. Дүүргийн малын тоо, жилээр



Иргэдийн хувийн мал 37840 толгой, аж ахуйн нэгж, байгууллагын мал 645 болж өмнөх оноос иргэдийн мал 666 толгойгоор (1.7%) буурсан.

2017 онд дүүргийн 6-р хорооны малын тоо 42.5 хувь, 9-р хороо 4.1 дахин, 12-р хороо 3.8 хувиар тус тус өсч, 4-р хороо 18.6 хувиар, 5-р хороо 30.3 хувиар, 8-р хороо 47.6 хувиар, 10-р хороо 35.7 хувиар, 11-р хороо 35.2 хувиар, 13-р хороо 0.5 хувиар, 14-р хороо 2.4 хувиар, 16-р хороо 58.1 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 11. Малын тоо, төрлөөр

Малын төрөл	2013	2014	2015	2016	2017	Өсөлт, бууралт	
						Тоо	Хувь
Малын тоо, бүгд	36990	42686	37520	38860	38485	-375	99.0
Тэмээ	4	15	1	7	1	-6	14.3
Адуу	5388	5895	5918	7451	6247	-1204	83.8
Үхэр	9583	11110	12043	12274	12616	342	102.8
Хонь	11584	14332	9944	9958	9894	-64	99.8
Ямаа	10431	11334	9614	9170	9727	557	106.1
Хонин толгойд шилжүүлснээр*	116206	132533	132286	144047	138078	5969	95.9

*Тайлбар: Коэффициент: 1 тэмээ-5 хонь, 1 адуу-7 хонь, 1 үхэр-6 хонь, 1 хонь-1 хонь, 1 ямаа-0.9 хонь


2017 оны малын тоо толгой өмнөх оноос 375 (1.0 %) толгойгоор буурсан байна. Үүнээс, тэмээ 6 толгойгоор (85.7%), адуу 1204 толгойгоор(16.2%), хонь 64 (0.6%) толгойгоор буурч, үхэр 342 толгойгоор (2.8%) , ямаа буюу 557 толгойгоор (6.1%) тус тус өсчээ.

Хүснэгт 12. Малын тоо, хороогоор


Хороо	2016	2017	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
4-р хороо	167	136	-	2	134	-	-	-18.6
5-р хороо	218	152	-	6	146	-	-	-30.3
6-р хороо	113	161	-	4	75	36	46	42.5
7-р хороо	198	-	-	-	-	-	-	-100
8-р хороо	850	445	-	109	202	34	100	-47.6
9-р хороо	200	1026	-	17	250	299	460	4.1
10-р хороо	677	435	-	29	220	78	108	-35.7
11-р хороо	71	46	1	-	45	-	-	-35.2
12-р хороо	5719	5939	-	434	2571	1086	1848	3.8
13-р хороо	13628	13555	-	1884	4820	3268	3583	-0.5
14-р хороо	16988	16577	-	3762	4140	5093	3582	-2.4
16-р хороо	31	13	-	-	13	-	-	-58.1
Дүн	38860	38485	1	6247	12616	9894	9727	-1.0

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 16577 толгой малаар 14-р хороо тэргүүлж, өмнөх оноос 411 толгой малаар буурсан байна. Хамгийн цөөн малтай нь 16-р хороо 13 толгой малтай байна.

Зураг 13. Малын тоо, сүргийн бүтцээр



Зураг 14. Малын тоо, оноор




Хүснэгт 13. Малын тоо, хороогоор

Хороо	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							Зөрүү	Хувь
4-р хороо	176	160	150	191	167	136	-31	-18.6
5-р хороо	129	147	127	157	218	152	-66	-30.3
6-р хороо	649	354	377	445	113	161	48	42.5
7-р хороо	76	92	44	66	198	-	-198	-100
8-р хороо	104	72	308	695	850	445	-405	-47.6
9-р хороо	144	109	132	173	200	1026	826	4.1*
10-р хороо	1167	1193	985	897	677	435	-242	-35.7
11-р хороо	167	104	82	59	71	46	25	-35.2
12-р хороо	4961	5297	5498	6196	5719	5939	220	3.8
13-р хороо	10702	11910	15316	15085	13628	13555	-73	-0.5
14-р хороо	17284	17291	19630	13507	16988	16577	-411	-2.4
16-р хороо	221	261	37	49	31	13	-18	-58.1
Бүгд	35780	36990	42686	37520	38860	38485	375	-1.0

*дахин

Мал төллөлт, төл бойжилт:

Зураг 15. Бойжуулсан төл, оноор



2017 онд 14833 хээлтэгч мал төллөж, 14922 төл гарсны 14180 төл (95.0%) бойжиж байна.

Бойжсон төлийн тоо өмнөх оноос 999 толгойгоор (7.6%) өсчээ.

Нийт бойжуулсан төлийн 0.1 хувийг ботго, 10.3 хувийг унага, 35.5 хувийг тугал, 28.7 хувийг хурга, 25.4 хувийг ишиг эзэлж байна.

Хүснэгт 14. Төл бойжилт, төрлөөр

	2016	2017	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	13562	14922	2	1603	5218	4262	3837
Бойжсон төл	13181	14180	2	1469	5038	4073	3598
Хорогдсон төл	381	742	-	134	180	189	239
Бойжилтын хувь	97.1	95.0	100	91.6	96.6	95.6	93.8

Том малын зүй бус хорогдол: 2017 онд оны эхний малын 1070 толгой (2.8%) том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 42.5 хувиар өсчээ. Нийт хорогдсон малын 13.3 хувийг адуу, 36.9 хувийг үхэр, 26.2 хувийг хонь, 23.6 хувийг ямаа эзэлж байна. Малын зүй бус хорогдлын 254 толгой (23.7%) мал өвчнөөр, 232 (21.7%) нь хээлтэгч малын хорогдол эзэлж байна.

Хүснэгт 15. Том малын зүй бус хорогдол

Үзүүлэлт	2016	2017	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	751	1070	-	142	395	280	253
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	42	254	-	4	207	23	20
Хорогдсон хээлтэгч	110	232	-	12	48	88	84

Тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын 2017 оны тооллогоор 74 өрх, 10 аж ахуйн нэгжийн 4174 гахай, 360722 шувуу, үүнээс 360201 тахиа тоологдсон байна. Өмнөх оноос гахайн тоо 16.6 хувиар буурч, шувуу болон тахианы тоо 11.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 16. Тэжээвэр амьтдын тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016	2017
Гахай	5952	6555	7901	5926	5007	4174
Шувуу	284729	240672	274887	269307	322527	360722
Үүнээс: тахиа	269158	240570	274676	268837	321340	360201
Зөгийн бүл	-	-	-	10	11	-

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн мал: Дүүргийн нутаг дэвсгэрийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд 2017 онд 2414 толгой мал тоологдож, өмнөх оноос 111 толгой (4.4%) малаар буурсан байна.

Мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын 0.1 хувийг тэмээ, 6.9 хувийг адуу, 44.9 хувийг үхэр, 18.5 хувийг хонь, 29.6 хувийг ямаа эзэлжээ.

Хүснэгт 17. Дүүргийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд байгаа малын тоо, 2017 он

Хороо	Малын төрлөөр					
	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
IV	-	2	134	-	-	136
V	-	6	146	-	-	152
VI	-	4	75	36	46	161
VIII	-	109	202	34	100	445
IX	-	17	250	299	460	1026
X	-	29	220	78	108	435
XI	1	-	45	-	-	46
XVI	-	-	13	-	-	13
Бүгд	1	167	1085	447	714	2414

Дүүргийн нийт 16 хороонд гэрийн тэжээвэр 5540 нохой, 128 муур байна. Бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 372 (6.3%) буурсан бол муурны тоо 10 (8.5%) өссөн байна.

Хүснэгт 18. Тэжээвэр нохой, муурны тоо, хороогоор

Хороо	Нохой			Муур		
	2016	2017	Өсөлт, бууралт	2016	2017	Өсөлт, бууралт
1-р хороо	13	22	69.2	3	6	1.0*
2-р хороо	37	28	-24.3	3	-	-
3-р хороо	13	13	-	3	3	-
4-р хороо	316	320	1.3	-	2	2.0*
5-р хороо	455	456	0.2	-	17	17.0*
6-р хороо	475	473	-0.4	10	9	-10
7-р хороо	371	351	-5.4	7	7	-
8-р хороо	761	753	-1.1	13	5	-61.5
9-р хороо	752	752	-	-	-	-
10-р хороо	628	634	0.9	-	6	6.0*
11-р хороо	75	72	-4	2	3	50.0
12-р хороо	434	121	-72.1	9	2	-77.8
13-р хороо	585	590	0.7	39	37	-5.2
14-р хороо	544	527	-3.1	24	22	-8.3
15-р хороо	26	23	-11.5	1	3	2.0*
16-р хороо	427	405	-5.1	1	6	5.0*
Нийт	5912	5540	-6.3	118	128	8.5

*дахин

Бэлтгэсэн хадлан тэжээл: Дүүргийн хэмжээнд 2017 онд 5464.5 тонн хадлан, гар тэжээл 1915.3 тонн, хужир шүү 204.4 тонн тус тус бэлтгэсэн байна. Өнгөрсөн онтой харьцуулахад хадлан 2134.8 тонн (1.6 дахин), гар тэжээл 1637.4 тонн (5.9 дахин), хужир шүү 172.1 тонн буюу (5.3 дахин) өссөн байна.

Хүснэгт 19. Бэлтгэсэн хадлан тэжээл, тн

Бэлтгэсэн хадлан тэжээл	2015	2016	2017	Өсөлт, бууралт
Хадлан	3477.8	3329.7	5464.5	64.1
Гар тэжээл	517.2	277.9	1915.3	5.9*
Хужир шүү	11.9	32.3	204.4	5.3*

* дахин



БАРИЛГА

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт 2017 онд нийт 578.4 тэрбум төгрөгийн өртөг бүхий 212 барилга, байгууламж баригдсан байна. Эдгээр барилга байгууламжийн 31.1 хувь нь төрийн, 68.9 хувь нь иргэний болон хувийн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар баригдаж байна. Мөн баригдаж буй объектуудыг давхарын хувьд бүлэглэн авч үзвэл 1-5 давхар 25.7 хувийг, 6-10 давхар 20.0 хувийг, 11-ээс дээш давхар 54.3 хувийг эзэлж байна.

Нийт гүйцэтгэлийн 81.6 хувийг шинэ барилга, өргөтгөлийн ажил, 18.4 хувийг их засварын ажил эзэлж байна. Шинэ барилга, өргөтгөл шинэчлэлийн ажлын гүйцэтгэлийн 21.7 хувийг орон сууцны барилга байгууламжийн ажил эзэлж байна.



ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн тохижилт үйлчилгээний төв 2017 онд хог цэвэрлэгээний ажлаар 982.3 мян.м2 зам талбайг цэвэрлэж, нийт 78.8 мянган тн хог тээвэрлэсэн байна. Тээвэрлэсэн нийт хогны 26.6 хувийг орон сууцнаас, 36.8 хувийг гэр хорооллоос, 29.1 хувийг аж ахуйн нэгж байгууллагаас, 7.5 хувийг зам талбайгаас тээвэрлэсэн хог эзэлж байна. 2017 онд дүүргийн хог цэвэрлэгээний ажилд зарцуулсан хөрөнгийн 585.5 сая төгрөгийг зам талбай цэвэрлэсэнд, 3.1 тэрбум төгрөгийг хог тээвэрлэхэд зарцуулжээ.

Хүснэгт 20. Хог цэвэрлэгээний ажил, зарцуулсан хөрөнгө

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ		Зарцуулсан хөрөнгө сая. төг	
		2016	2017	2016	2017
Цэвэрлэсэн зам талбай	мян.м2	773.9	982.3	431.7	585.5
Тээвэрлэсэн хог	тн	70896.5	78802.4	2900.2	3149.2
Үүнээс: Орон сууцнаас	тн	13981.8	20980.0	593.7	838.4
Гэр хорооллоос	тн	34084.4	28996.3	1396.4	1158.7
ААНБ-аас	тн	19843.4	22903.6	790.6	915.2
Зам талбайгаас	тн	2986.9	5922.6	119.5	236.9



МЭДЭЭЛЭЛ ХОЛБОО

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 2017 оны 4-р улиралд 70.1 сая төгрөг болсон байна. Интернэтийн үйлчилгээг байнгын хэрэглэгч 50 хүн, интернэт үйлчилгээний цэгээр 500 хүн үйлчлүүлсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээний орлого 149.4 төгрөгөөр (68.0%) буурчээ.

Хүснэгт 21. Мэдээлэл, холбооны салбарын үндсэн үзүүлэлт, IV улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017
Нийт орлого	мян.төг	219465.3	70100.0
Үүнээс: Хүн амаас орсон орлого	мян.төг	219465.3	70100.0
Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчдийн тоо	хүн	512	500
Интернэтийн байнгын хэрэглэгч	хүн	55	50



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Дүүргийн нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүд 2017 оны 4-р улиралд давхардсан тоогоор 1528.3 мянган хүн тээвэрлэж, 917.4 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Өмнөх оны мөн үеэс үйлчилгээний орлого 367.5 сая төгрөгөөр (28.6%) буурсан байна.

Хүснэгт 22. Тээврийн салбарын үндсэн үзүүлэлт, IV улиралд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016	2017
Нийт орлого	сая.төгрөг	1284.9	917.4
Тээвэрлэсэн ачаа	мян.тн	1.0	1.3
Ачаа эргэлт	мян.т.км	47.6	50.4
Зорчигчдын тоо	мян.хүн	1840.3	1528.3
Зорчигч эргэлт	мян.хүн.км	6257	5196.2


Тээврийн салбарын 4-р улирлын орлогын бууралтад ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа түр зогссон нь нөлөөлжээ.

Автомашин тоо: Дүүргийн хэмжээнд 2017 оны техникийн хяналтын үзлэгт 37.9 мянган автомашин хамрагдсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 77.3 хувийг суудлын автомашин, 16.8 хувь нь ачааны, 3.6 хувь нь автобус, 2.2 хувь нь тусгай зориулалтын автомашин эзэлж байна.


Хүснэгт 23. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины тоо

	2015	2016	2017	Автомашин төрлөөр				Амины автомашин	
				Суудлын	Ачааны	Автобус	Тусгай	2016	2017
Дүүргийн дүн	32344	34444	37954	29367	6386	1370	831	27316	29077

Зураг 16. Автомашины тоо, ашиглалтын хугацаагаар



Зураг 17. Хүрдний байрлал зүүн талдаа автомашины тоо, үндсэн төрлөөр



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

2017 оны эцэст нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 15.2 хувь нь жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжинд, 3.8 хувь нь алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжинд тус тус хуваарилсан байна.

Харин зарлагын 63.4 хувь нь нийгмийн халамжийн санд буюу нийт 26178 хүнд, 7625 хүнд алдарт эхийн одонгийн тусламж, 598 хүнд алдар цолтой ахмадын хөнгөлөлт, тусламж, 8327 хүнд жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмжийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 24. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт, 2017 оны XII сард, сая.төг

Үзүүлэлт	Дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн сангийн орлого	14 409.2	
1.Нийслэлийн төсвийн санхүүжилтийн орлого	11 771.5	
а) Нийгмийн халамжийн сан	8 965.6	
б) жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	2 195.3	
в) ОНОТХаламжийн үйлчилгээ	173.5	
г) хүнс тэжээл хөтөлбөр	437.1	
2. Улсын төсвийн санхүүжилтийн орлого	2 623.4	
а) алдарт эхийн одонгийн тусламж	1 005.0	
б) алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	556.0	
В) насны хишиг	1 062.4	
3. Үйлчилгээний орлого	14.3	
а) хүүгийн орлого	11.6	
б) маягтын орлого		
в) бусад орлого	2.7	
Зарлагын нийт дүн	14 325.0	51 124
1. Нийгмийн халамжийн сан	9 087.6	26178
2. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж	2099.8	8 327
3. Алдарт эхийн одонгийн тусламж	1000.2	7 625
4. Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	563.2	598
5. Хүнс тэжээл хөтөлбөр	413.1	1416
6. ОНОТХ Үйлчилгээний зардал	102.6	432
7. Насны хишиг	1 058.5	6 548



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 2017 онд 3172 байгууллагын нийт 195.3 мянга гаруй хүн хамрагдаж, шимтгэл төлсөн ба тэдгээрийн 69.4 мянга (35.5%) нь ААНБ-ын, 11.7 мянга (6.0%) нь төсвийн байгууллагын, 9.9 мянга (5.1%) нь сайн дурын даатгуулагчид, 104.3 мянга (53.4%) нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчид байна.

Хүснэгт 25. Нийгмийн даатгалын байгууллагаар үйлчлүүлсэн байгууллага болон даатгуулагчийн тоо

Үзүүлэлт	2016.XII	2017.XII	Өсөлт	
			тоо	хувь
Нийт байгууллагын тоо	2982	3172	190	106.4
Аж ахуйн нэгж байгууллагын тоо	2863	3050	187	106.5
Төсөвт байгууллагын тоо	119	122	3	102.5
Нийт даатгуулагчдын тоо	168070	195327	27257	116.8
ААНБ-ын даатгуулагчийн тоо	59397	69388	9991	116.8
Төсөвт байгууллагын даатгуулагчийн тоо	10783	11664	881	108.2
Сайн дурын даатгуулагчийн тоо	9364	9948	584	106.2
Эрүүл мэндийн даатгуулагчийн тоо	88526	104327	15801	117.8

2017 онд дүүргийн нийгмийн даатгалын сангийн нийт орлого 143.2 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 9.2 тэрбум төгрөгөөр (6.8%) давж биелсэн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлтийн хувийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 26. Нийгмийн даатгалын сангийн орлого, сан түс бүрээр

Үзүүлэлт	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Биелэлт %	
	2016.XII	2017.XII	2016.XII	2017.XII	2016	2017
Тэтгэврийн даатгалын сангийн орлого	68768	83536.4	71097.5	91786.8	103.4	109.9
Тэтгэмжийн сангийн орлого	7407.6	10236.9	8103.6	10494.4	109.4	102.5
ҮОМШӨ*-ний даатгалын орлого	8275	11419.4	9924.1	12298.4	119.9	107.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого	1904.5	2481	1945.6	2534.1	102.2	102.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	20874.7	26321.9	22241.6	26057.1	106.5	99.0
Нийт	107229.8	133995.6	113312.4	143170.8	105.7	106.8


Тайлбар: ҮОМШӨ-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин

Даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 64.1 хувийг тэтгэврийн даатгалын санд, 7.3 хувийг тэтгэмжийн даатгалын санд, 8.6 хувийг ҮОМШӨ-ний даатгалын санд, 1.8 хувийг ажилгүйдлийн даатгалын санд, 18.2 хувийг эрүүл мэндийн даатгалын сангийн орлого түс түс эзэлж байна.

Зураг18. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувиар



Зураг 19. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар




Тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 13 633 хүнд 57.4 тэрбум төгрөгийг, тахир дутуугийн тэтгэвэр авагч 2 962 хүнд 8.3 тэрбум төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 796 хүнд 2.3 тэрбум төгрөгийг, цэргийн тэтгэвэр авагч 1 074 хүнд 6.7 тэрбум төгрөгийг түс түс олгосон байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 12 032 хүнд 1.8 тэрбум төгрөгийг, жирэмсэн болон амаржсан 4 227 хүнд 6.1 тэрбум төгрөгийг, 59 хүнд оршуулгын тэтгэмж 59.0 сая төгрөгийг түс түс олгожээ.


ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагч 165 хүнд 884.3 сая төгрөгийг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 17 хүнд 69.4 сая төгрөгийг, тэтгэмж төлбөрт 98 хүнд 67.3 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний сувилалд 34 хүнд 6.4 сая төгрөгийн түс түс олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 1 870 хүнд 3.7 тэрбум төгрөг зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зардлын 62.8 хувийг тэтгэврийн, 7.7 хувийг тэтгэмжийн, 7.5 хувийг ҮОМШӨ-ний, 2.5 хувийг ажилгүйдлийн 19.5 хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон зардал эзэлж байна.

Зураг 20. Даатгалын сангийн орлого, зарлага сая.төг



Зураг 21. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 2017 оны 12-р сард 565 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1326 хүнээр буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 58.0 хувь нь эмэгтэйчүүд байна.


2017 оны 12-р сард орон тооны цомхтголоор 72, байгууллага татан буугдсанаас 28, өөр газраас шилжиж ирсэн 41, сургууль төгссөн 33, цэргээс халагдсан 6, мэргэжлийн ажил олдохгүй 38, цалин багатайгаас 199, бусад шалтгаанаар 154 хүн ажилгүй болжээ.

Тайлант сард 163 хүн ажилд орсноос улсын үйлдвэрийн газарт 4, төрийн төсөвт байгууллагад 46, нөхөрлөл компанид 68, бусад байгууллагад 45 хүн ажилд орсон байна.

Хүснэгт 27. Бүртгэлтэй ажилгүйчүүд, боловсролын түвшнээр, жил бүрийн XII сарын эцэст

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо			Дүнд эзлэх хувь		
	2015.XII	2016.XII	2017.XII	2015.XII	2016.XII	2017.XII
Нийт ажилгүйчүүд	1 350	1 891	565	100.0	100.0	100.0
Дээд боловсролтой	658	1025	280	48.7	54.2	49.5
Тусгай дунд боловсролтой	80	97	28	5.9	5.1	5.0
Мэргэжлийн анхан шатны	63	91	10	4.7	4.8	1.8
Бүрэн дунд боловсролтой	498	649	236	36.9	34.3	41.8
Бүрэн бус дунд боловсролтой	38	20	7	2.8	1.1	1.2
Бага, боловсролгүй	13	9	4	1.0	0.5	0.7

Зураг 22. Ажилгүйчүүд насны бүлгээр, XII сарын эцэст



Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 226 (40.0%) нь анх удаа ажил хайж байгаа бол 339 (60.0%) нь урьд ямар нэг ажил хийж байжээ.

Насны бүлгээр авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 42 (7.4%) нь 16-24 насны, 246 (43.5%) нь 25-34 насны, 164 (29.0%) нь 35-44 насны, 113 (20.0%) нь 45-60 насны хүмүүс байна.




ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


Дүүргийн хэмжээнд 2017 оны эцэст 2386 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 961 (28.7%) хүнээр, 10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 77.7 продицимилээр буурсан байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн 26.1 хувийг салхин цэцэг, 10.6 хувийг шинээр илэрсэн сүрьеэ, 4.9 хувийг тэмбүү, 18.6 хувийг гар хөл амны өвчин, 3.4 хувийг трихомониаз, 15.7 хувийг цусан суулга, 1.5 хувийг заг хүйтэн, 1.2 хувийг вируст гепатит, 0.6 хувийг гахайн хавдар, 17.4 хувийг бусад өвчнөөр өвчлөгчид тус тус эзэлж байна.

Зураг 23. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



Зураг 24. Халдварт өвчнөөр өвчлөгчид



2017 оны эцэст төрөхийн улмаас эндсэн эхийн тоо өмнөх оны мөн үеэс 1 эхээр буурч, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл өмнөх оны мөн үеэс 1 эхээр нэмэгдэж, нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Хүснэгт 28. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эцэст

Үзүүлэлт	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	$\frac{2017}{2016} \%$
Амаржсан эхийн тоо	4487	4586	4369	-4.7
Амьд төрсөн хүүхэд	4510	4613	4400	-4.6
Төрөхийн улмаас эндсэн эх	1	2	1	-50
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	41	44	44	-
1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд	5	12	13	8.3

Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв

Хүснэгт 29. Дүүрэгт гарсан халдварт өвчин, эхний XII сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-XII	2017 I-XII	Өсөлт, бууралт 2017/2016	
				тоо/пункт	Хувь
НИЙТ ХАЛДВАРТ ӨВЧИН	Бодит тоо 10000 хүнд	3347 231.4	2386 153.7	-961 -77.7	-28.7
Вируст гепатит	Бодит тоо 10000 хүнд	27 1.9	29 1.9	2 -	7.4
Цусан суулга	Бодит тоо 10000 хүнд	258 17.8	375 24.2	117 6.4	45.3
Улаан эсэргэнэ	Бодит тоо 10000 хүнд	120 8.3	194 12.5	74 4.2	1.6 дах
Сальмонеллөз	Бодит тоо 10000 хүнд	22 1.5	12 0.8	-10 -0.7	-45.4
Салхин цэцэг	Бодит тоо 10000 хүнд	425 29.4	623 40.1	198 10.7	46.5
Гахайн хавдар	Бодит тоо 10000 хүнд	25 1.7	14 0.9	-11 -0.8	-44
Ёлом	Бодит тоо 10000 хүнд	12 0.8	12 0.8	- -	-
Гар хөл, амны өвчин	Бодит тоо 10000 хүнд	455 31.5	444 28.6	-11 -2.9	-2.4
Тэмбүү	Бодит тоо 10000 хүнд	120 8.3	118 7.6	-2 -0.7	-1.6
Заг хүйтэн	Бодит тоо 10000 хүнд	48 3.3	35 2.3	-13 -1.0	-27.0
Трихомониаз	Бодит тоо 10000 хүнд	115 7.9	82 5.3	-33 -2.6	-28.7
Шинээр илэрсэн сүрьеэ	Бодит тоо 10000 хүнд	267 18.5	253 16.3	-14 -2.2	-5.2
Мөөгөнцөр	Бодит тоо 10000 хүнд	15 1.0	3 0.2	-12 -0.8	-80
Улаан бурхан	Бодит тоо 10000 хүнд	1366 94.4	1 0.1	-1365 -94.3	-99.9
Бусад өвчлөл	Бодит тоо 10000 хүнд	72 5.1	191 12.5	119 7.4	2.6 дах



БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2017-2018 оны хичээлийн жилд Хан-Уул дүүргийн төрийн болон, төрийн өмчийн бүс нийт 35 ерөнхий боловсролын сургуульд нийт 28057 хүүхэд суралцаж байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад суралцагчдын тоо 10.5 хувиар өссөн байна. Сургуулийн өмнөх боловсролын төрийн болон, төрийн бүс өмчийн нийт 112 цэцэрлэгт 16105 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 14.6 хувиар өссөн байна. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байршин үйл ажиллагаа явуулж байгаа 12 их, дээд сургуульд 16892 оюутан суралцаж байна.

Хүснэгт 30. СӨБ-ын байгууллагын үндсэн үзүүлэлт, хичээлийн жилээр

Үзүүлэлт	2015/16	2016/17	2017/18
СӨБ-ын байгууллагын тоо	88	108	112
СӨБ-д хамрагдагчдын тоо	11705	14048	16105
Цэцэрлэгийн үндсэн багшийн тоо	391	497	561

Хүснэгт 31. ЕБС, их дээд сургуулийн үндсэн үзүүлэлт, хичээлийн жилээр

Үзүүлэлт	2015/16	2016/17	2017/18
Ерөнхий боловсролын сургуулийн тоо	30	33	35
Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо	22715	25383	28057
Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багшийн тоо	1201	1254	1389
Их, дээд сургуулийн тоо	9	11	12
Их, дээд сургуульд суралцагч оюутны тоо	18929	14968	16892


Мэдээллийн эх сурвалж: Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтэс



ГЭМТ ХЭРЭГ

Дүүргийн хэмжээнд 2017 оны эцэст (урьдчилсан байдлаар) 1900 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 261 (15.9%) хэргээр өсчээ.

Зураг 25. Гэмт хэргийн тоо



Нийт гэмт хэргийн 645 (33.9%) нь хулгайн хэрэг, 533 (28.1%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, 196 (10.3%) хэрэг нь залилан мэхлэх гэмт хэрэг, 47 (2.5%) хэрэг нь олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах хэрэг, 37 (1.9%) нь хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг, 19 (1.0%) нь хүчингийн хэрэг, 51 (2.7%) нь дээрэмдэх хэрэг, 88 (4.6%) нь ХАБТХАЖЭ хэрэг, 7 (0.4%) нь хүнийг алах хэрэг, 9 (0.5%) нь малын хулгайн хэрэг, 268 (14.1%) нь бусад гэмт хэргүүд тус тус эзэлж байна.


Хүснэгт 32. Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Гэмт хэргийн төрөл	Гэмт хэргийн тоо		Өсөлт, бууралт	
	2016.I-XII	2017.I-XII	$\frac{2017}{2016} \%$	Тоо
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	13	37	184.6	24
Хүчин	11	19	72.7	8
Дээрэмдэх	36	51	41.7	15
Хулгай	451	645	43.0	194
Залилан мэхлэх	190	196	3.2	6
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	524	533	1.7	9
Малын хулгай	10	9	-10.0	-1
Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	95	47	-50.5	-48
Хүнийг санаатай алах	5	7	40.0	2
ХАБТХАЖЭ	90	88	-2.2	-2
Бусад	214	268	25.2	54
Бүгд	1639	1900	15.9	261

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг

Нийт хулгайн хэрэг 645 байгаагаас 91.2 хувь нь иргэний өмчийн хулгай, 4.0 хувь нь халаасны хулгай, 1.2 хувь нь авто тээврийн хэрэгслийн хулгайн хэрэг эзэлж байна.

Зураг 26. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор



Хүснэгт 33. Бүртгэгдсэн гэмт хэрэг, хороогоор

Хороо	Гэмт хэрэг		Өөрчлөлт		Хүнийг алах	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	Үүнээс Гэр бүлийн хүчирхийлэл	Хүчин	Хулгай	Үүнээс			Дээрэмдэх	Залилан мэхлэх	Малын хулгай	Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах	ХАБТХАЖЭ	Бусад
	2016.I-XII сар	2017.I-XII сар	Тоо	%							ИӨХ	Авто тээврийн хэрэгсэл хулгайлах	Халаасны хулгай						
1	89	103	14	15.7	0	1	27	1	2	22	16	1	3	12	16	0	2	5	16
2	186	200	14	7.5	0	2	53	1	1	47	40	3	2	11	35	0	6	8	37
3	201	207	6	3.0	1	6	64	3	2	42	36	1	1	5	24	0	6	13	44
4	126	151	25	19.8	2	2	38	1	1	74	63	0	9	5	8	1	2	5	13
5	39	45	6	15.4	0	3	12	0	1	15	14	0	1	0	1	0	1	2	10
6	23	52	29	126.1	0	1	18	2	1	16	16	0	0	0	0	0	2	6	8
7	30	42	12	40.0	0	3	10	0	0	18	18	0	0	0	1	0	2	2	6
8	63	80	17	27.0	1	3	30	4	0	36	35	0	0	0	1	1	2	1	5
9	60	62	2	3.3	0	1	21	3	1	22	22	0	0	1	2	1	4	5	4
10	151	165	14	9.3	0	2	52	1	1	52	47	1	0	6	9	1	6	15	21
11	191	240	49	25.7	0	7	67	5	1	96	89	0	6	0	34	0	0	3	32
12	49	67	18	36.7	0	2	18	1	0	33	31	0	0	0	2	2	2	2	6
13	29	52	23	79.3	0	1	16	0	3	21	18	0	0	1	0	2	1	4	3
14	52	67	15	28.8	1	1	10	0	4	34	32	0	0	2	3	1	1	5	5
15	272	274	2	0.7	2	0	73	3	1	74	69	2	3	6	52	0	8	10	48
16	78	93	15	19.2	0	2	24	1	0	43	42	0	1	2	8	0	2	2	10
Дүн	1639	1900	261	15.9	7	37	533	26	19	645	588	8	26	51	196	9	47	88	268

*ХАБТХАЖЭ-хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг



АМЬДАРЧ БҮЙ ОРЧИН

Нийслэлийн агаарын дундаж хэм 2017 оны 12-р сард дунджаар -16.7°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс -0.2°C -аар, олон жилийн дундажтай харьцуулбал -0.2°C -аар тус тус хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм -1.5°C , хамгийн хүйтэн хэм -25.5°C , хүр тунадасны нийлбэр 2.4 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 10 метр секунд хүрчээ. Цасан бүрхүүлийн үнэмлэхүй зузаан 11 сантиметр, шороон болон цасан шуургатай 2 өдөр бүртгэгдсэн байна.

Хүснэгт 34. Хан-Уул дүүргийн агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, $\text{мг}/\text{м}^3$, XII-р сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Хүлцэх агууламж	Мишээл – экспо төв			Нисэх		
			2015 XII	2016 XII	2017 XII	2015 XII	2016 XII	2017 XII
			$\text{Мг}/\text{м}^3$					
Хүхэрлэг хий SO_2	Дундаж	0.050 ¹	-	-	-	0.032	0.033	0.012
	Хамгийн их		-	-	-	0.068	0.047	0.021
	ХА-аас давсан хувь		-	-	-	83.0	-	-
	ХТ- хоногоор		-	-	-	30	19	17
Азотын давхар исэл NO_2	Дундаж	0.050 ¹	-	-	-	0.031	0.038	0.025
	Хамгийн их		-	-	-	0.047	0.049	0.037
	ХА-аас давсан хувь		-	-	-	3.0	-	-
	ХТ- хоногоор		-	-	-	30	19	17
Нүүрстөрөгчийн дутуу исэл CO	Дундаж	10.000 ²	-	-	2.952	1.686	1.731	1.621
	Хамгийн их		-	-	5.563	3.589	3.183	3.345
	ХА-аас давсан хувь		-	-	-	-	-	-
	ХТ- хоногоор		-	-	21	92	61	51
Тоос PM_{10}	Дундаж	0.100 ¹	0.098	0.113	0.118	0.152	0.158	0.157
	Хамгийн их		0.245	0.237	0.320	0.311	0.252	0.311
	ХА-аас давсан хувь		39.0	48.3	48.0	83.0	100.0	65.0
	ХТ- хоногоор		31	29	31	30	22	17
Тоос PM_{25}	Дундаж	0.050 ¹	-	-	-	0.141	0.148	0.146
	Хамгийн их		-	-	-	0.286	0.238	0.302
	ХА-аас давсан хувь		-	-	-	93.0	100.0	100.0
	ХТ- хоногоор		-	-	-	30	22	17
Озон O_3	Дундаж	0.100 ²	0.0039	-	0.012	0.006	0.008	0.017
	Хамгийн их		0.071	-	0.036	0.028	0.027	0.027
	ХА-аас давсан хувь		-	-	-	-	-	-
	ХТ- хоногоор		64	-	93	92	61	51

*- Хүлцэх хэм хэмжээ, **- CO , O_3 -ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Эх үүсвэр: “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны XII сарын танилцуулга

Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2017 оны 12-р сарын 06, 07-ны өдрүүдэд хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд бохирдуулагч бодисын хэмжээ хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд нитридийн нэгдлийн хэмжээ хэвийн, хүчилтөрөгчийн хэмжээ горим алдагдаж бохирдолтой, амоны азот 74.2 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 48.0 дахин, эрдэс фосфор 27.4 дахин хүлцэх хэм хэмжээнээс давж, Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 35. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, XII-р сард¹

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.64	Хэвийн	1.12	Горим алдагдсан
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤ 3	1.8	Хэвийн	144.0	48.0 дахин
Нитридийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.002	Хэвийн	0.012	Хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.05	Хэвийн	37.08	74.2 дахин
Эрдэс фосфор	P	≤0.1	0.010	Хэвийн	2.738	27.4 дахин

*Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

ЗАХИРГААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны эцэст Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэдээс 3306 өргөдөл, гомдол ирсний 2737-г нь хуулийн дагуу хугацаанд нь хариу өгч ажиллажээ. Шийдвэрлэх хугацаа болоогүй 560 өргөдөл байна.

Хүснэгт 36. Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ

Байгууллагын нэр	Өргөдөл гомдлын тоо	Хэлбэр				Агуулга				Бусад байгууллагад шилжүүлсэн	Хуулийн хугацаанд хариу өгсөн	Хүлээгдэж байгаа	Хугацаа болоогүй	Хугацаа хэтэрсэн
		Амаар	Бичгээр	Утсаар	Цахим сүлжээгээр	Гомдол	Санал	Мэдэгдэл	Хүсэлт					
ТЗУХ	347		324		23	21			326		343		4	
СТСХ	2		1		1	1			1		2			
ТГХШХ	9		9						9		9			
НХХ	53		49		4	6			47		53			
ТНААХ	192		129		63	68	1		123		191		1	
ХХҮХ	68		59		9	13	1		54		68			
Цэргийн штаб	123		123						123		123			
Хууль зүйн тасаг	44		42		2	10		1	33		44			
ЗДТГ-ын дүн	838		736		102	119	2	1	716		833		5	
ХХ														
ХХҮХ	192		184		8	2			190		192			
Газрын алба	1566		1400		166				1566		1015		551	
БоХ	135		58	6	71	57	12	6	60	9	125		1	
ОБХ														
Албан бус- НТБ төв	508	508							508		508			
БХ	67		62		5	1			66		64		3	
Дэргэдэх хэлтэс албадын дүн	2468	508	1704	6	250	60	12	6	2390	9	1904		555	

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
Танилцуулгыг эрхлэн гаргасан: мэргэжилтэн Б. Энхжаргал

“Хан-Уул дүүргийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2017 оны XII сарын танилцуулга

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?



 Цахимаар:

www.1212.mn

Статистик мэдээллийн
нэгдсэн сан



www.nso.mn

Та статистик мэдээллийг байнга
авч байхыг хүсвэл **ЭНД ДАРЖ**
бүртгүүлнэ үү

Энэ хэсэгт өөрийн e-mail
хаягаа бүртгүүлснээр
статистикийн мэдээллийг
цаг алдалгүй тогтмол авч
байх болно.

SOCIAL NETWORK



[www.facebook.com/
Статистик-Мэдээлэл](http://www.facebook.com/Статистик-Мэдээлэл)



[www.twitter.com/
statistic_mn](http://www.twitter.com/statistic_mn)



Ухаалаг гар утас, таблет
ашиглан статистик мэдээлэл
авах ezStat аппликейшн



Статистикийн хэвлэмэл
бүтээгдэхүүнийг унших
Монстат аппликейшн



Download on the
App Store

 **Google play**



Утсаар:



Лавлах утас

1900-1212

QR код уншуулж татаж авна уу.

